

**“ШИВЭЭ ОВОО” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2015.11.04

Улаанбаатар хот

“Шивээ Овоо” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2015 оны 11 дүгээр сарын 04-ны өдрийн 14:00 цагт Шивээ Овоо ХК-ийн Улаанбаатар хот дахь төлөөлөгчийн газарт боллоо.

Хувьцаа эзэмшигчдийн хуралд төрийн эзэмшлийн хувьцааны 90 хувийг төлөөлж итгэмжлэлээр “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Тэргүүн дэд захирал Б.Ариунболд, Уул уурхайн яамны төрийн нарийн бичгийн дарга Д.Артаг, мөн хувьцааны 8,9 хувийг эзэмшигч Fire Bird сангийн зүгээс брокерийн байгууллагаар дамжуулан бичгээр 5 санал өгсөн бөгөөд төлөөлөгч Б.Пүрэвбаатар мөн бусад хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл болох Ц.Самданпунцаг, Д.Энхтуяа, Ж.Баатар зэрэг 3-н хүн оролцлоо.

“Шивээ Овоо” ХК-ийн зүгээс Гүйцэтгэх захирал О.Отгонбаатар, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Д.Болд, Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга О.Чинхүсэл, Эрдэнэс Монгол ХХК-ийн Сан хувьцаа хариуцсан хэлтсийн дарга Д.Соёл, Эрдэнэс Монгол ХХК-ийн хуулийн мэргэжилтэн Б.Түвшинтер, Тоологын комиссын дарга С.Одбаяр, гишүүн Д.Ганбаатар, С.Боргил нар мөн оролцлоо.

“Шивээ Овоо” ХК-ийн гүйцэтгэх захирал О.Отгонбаатар: “Шивээ Овоо” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд хүрэдцэн ирсэн та бүхэнд баярлалаа. Энэхүү хурлыг Улсын Их Хурлын 2015 оны 70 дугаар тогтоол, Засгийн газрын 330 дугаар тогтоолын дагуу Шивээ Овоо ХК-ийн хувьцааны төрийн эзэмшлийн хувьцааг нэмэлт хувьцаа гаргах замаар 51 хувь хүртэл бууруулах үүднээс зохион байгуулж байгаа болно. Гүйцэтгэх захиралын 13 зүгээс хуралд ирсэн төлөөлөгчдийг танилцуулав. Компанийн хуулийн дагуу хурлын дарга хурлыг зохион байгуулна уу гэж хүсье гэв.

Хурлын дарга: Та бүхэн сайн байцгаана уу. Улсын Их Хурлын 2015 оны 70 дугаар тогтоол, Засгийн газрын 330 дугаар тогтоолын дагуу Шивээ овоогийн менежментийг сайжруулах үүднээс төрийн эзэмшлийн хувьцааг нэмэлт хувьцаа гаргах замаар 51 хувь хүртэл бууруулах тогтоол шийдвэр гарсаны дагуу энэхүү хурал болж байна. Тооллогын комисс хурлын ирцийг танилцуул гэв.

Тооллогын комиссын дарга С.Одбаяр: Шивээ Овоо” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ирвэл зохих 13,419,101 ширхэг хувьцаа эзэмшдэг 1600 хувьцаа эзэмшигчдээс брокерын пүүсүүдээр дамжуулан хуралд оролцох санал 5 ирсэн. 13,212,617ш хувьцаа эзэмшдэг нийт 6 хувьцаа эзэмшигчдийг төлөөлж 2 хүн итгэмжлэлээр, 3274 ширхэг хувьцаа эзэмшдэг 3 хүн өөрийн биеээр ирж нийт 13,215,891 хувьцаатай хувьцаа эзэмшигчид хуралд оролцож хурлын ирц 98.48 хувьтай байна. Хурлыг нээж болно гэв.

Хурлын дарга: Хурлын дэгийг танилцуулаад баталья гэв.

№	ХУРЛЫН ДЭГ	ХУГАЦАА, ЦАГ, МИНУТ
1	Хурлын ирц бүртгэх / Тооллогын комисс/	13:30-14:00 цагт
2	Хурлын ирц мэдээллэх / Зохион байгуулах комисс/	5 минут

3	Хувьцаа эзэмшигчдийн хурлын даргыг сонгох	5 минут
4	Хурлын дарга хурлын ажиллагааг нээж, хурлаар хэлэлцэх асуудал, хурлын дэгийг танилцуулах	10 минут
5	Хэлэлцэх асуудлыг дарааллын дагуу танилцуулж хэлэлцүүлэх	Асуудал тус бүр дээр 30 хүртэл минут
6	Хуралд оролцогсдын асуулт, хариулт, санал дүгнэлт авах	Хүн тус бүрээс 5 минут
7	Завсарлага	15 минут
8	Тооллогын комиссын тогтоолыг танилцуулах	5 минут
9	Хурлаас гарах шийдвэр, тогтоолын төслийг танилцуулах	15 минут
10	Хурлын ажиллагааг хаах	5 минут

Хурлын дэгийг баталах уу. Хуралд ороцож буй нийт оролцогчдийн саналаар хурлын дэгийг дээрх байдлаар батлав.

Хурлын дарга: “Шивээ Овоо” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 22 дугаар тогтоол, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 32 дугаар тогтоол, Гүйцэтгэх захирлын итгэмжлэлийн дагуу хурлыг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн тэргүүн дэд захирал Б.Ариунболд даргалж явуулахаар боллоо. Төлөөлөн удирдах зөвлөлийн 32 дугаар тогтоол, Гүйцэтгэх захирлын итгэмжлэлийг уншиж сонсгов. Хурлын нийт гишүүдээс хурлыг даргалах талаар эсрэг санал гараагүй бөгөөд нийт гишүүдийн саналаар даргалагчийг Б.Ариунболд батлав.

Хурлын дарга: Хэлэлцэх асуудалаа одоо баталья. Та бүхэнд тараасан материалын хуудасны эхний хуудас тус бүрд байгаа гэв.

1. Компанийн дүрмийн 4.1 дүгээр зүйлд заасан Зарласан хувьцааны тоог 23,680,766 ш болгох өөрчлөлтийг оруулах тухай
2. Компанийн дүрмийн 12.6.3-дугаар заалтыг өөрчлөн найруулах тухай
3. Компанийн дүрмийн 10.9, 10.10.10 дүгээр заалтыг хүчингүй болгож 11.1.5 дугаар заалтыг өөрчлөн найруулах тухай
4. “Шивээ Овоо” ХК-ийн зарласан хувьцаанаас 10,261,665 ширхэг хувьцааг хөрөнгийн зах зээлд нэмэлтээр гаргаж олон нийтэд арилжаалах тухай
5. Шинээр олон нийтэд арилжаалах хувьцааг хувьцаа эзэмшигчид тэргүүн ээлжинд худалдан авах эрх эдлүүлэх эсэх тухай
6. Олон нийтэд санал болгон арилжаалах хувьцааны санал болгох нэгжийн үнийг тогтоох эрхийг Төлөөлөн удирдах зөвлөлд олгох тухай

Эдгээр 6-н асуудалтай холбоотойгоор 5 дугаар асуудлыг дараагийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх санал өгөхийг удирдамжаар өгсөн байна. Тэгэхээр энэ асуудлыг хэлэлцэх шаардлагагүй байна. Хэлэлцэх асуудлыг дээрх 5-н асуудлаар хийхээр санал хураая гэв. Бүх гишүүдийн саналаар хурлын хэлэлцэх асуудлыг батлав.

Хурлын дарга: Компанийн дүрмийн 4.1 дүгээр зүйлд заасан Зарласан хувьцааны тоог 23,680,766 ш болгох өөрчлөлтийг оруулах тухай асуудлыг эхлээд танилцуулья. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүү Д.Болд танилцуулна.

Д.Болд: "Шивээ Овоо" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хуралд хүрэлцэн ирсэн Та бүхэнд энэ өдрийн мэнд дэвшүүлье.

Монгол Улсын Их Хурлын 2015 оны 70 тоот тогтоолоор "Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл", Засгийн газрын 2015 оны 330 тоот тогтоолоор "2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн жагсаалт"-ыг тус тус баталсан бөгөөд эдгээр тогтоолын хэрэгжилтийн хүрээнд "Шивээ Овоо" ХК-ийн техник технологийг шинэчлэх, компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх хөрөнгийг татан төвлөрүүлэхийн тулд хувьцаа нэмж гаргах замаар төрийн эзэмшлийн хувь хэмжээг 51 хүртэл хувь байх хэмжээнд бууруулах шаардлага үүсээд байна.

"Шивээ Овоо" ХК нь нийт 13,419,101 ширхэг энгийн хувьцаатай бөгөөд төрийн эзэмшилд 90 хувь буюу 12,077,191 ширхэг, 10 хувь буюу 1,341,910 ширхэг хувьцаа бусад хувьцаа эзэмшигчдийн нэр дээр бүртгэлтэй байдаг. Компанийн тухай хуулийн 31.2.2 дахь заалтад заасны дагуу хувьцаа нэмж гаргах замаар төрийн эзэмшлийн хувь хэмжээг 51 хүртэл бууруулахын тулд 10,261,665 ширхэг хувьцааг нэмж гаргах шаардлагатай бөгөөд зах зээлийн зарчмаар төрийн болон бусад хувьцаа эзэмшигчдийн хувьцааны тоо ширхэгт өөрчлөлт орохгүй боловч төрийн эзэмшлийн хувь хэмжээ 51 хувь, бусад хувьцаа эзэмшигчдийн эзэмшлийн хувь хэмжээ 5,66 хувь болон буурч, шинээр 43,33 хувьтай тэнцэх хэмжээний хувьцааг нэмж гаргахаар байна. Ингэснээр "Шивээ Овоо" ХК нь нийт 23,680,766 ширхэг энгийн хувьцаатай болох бөгөөд 12,077,191 /51 хувь/ ширхэг нь төрийн эзэмшилд, 1,341,910 /5,66 хувь/ ширхэг нь бусад хувьцаа эзэмшигчдэд, 10,261,665 /43,33 хувь/ ширхэг хувьцааг нийтэд нээлттэй арилжаалахад худалдан авах бусад хувьцаа эзэмшигчид байхаар төлөвлөгдөж байна. Ийнхүү хувьцаа нэмж гаргасантай холбогдуулан нийт хувьцаа эзэмшигчид дотроос хувь хэмжээ нь хамгийн ихээр буурч, хөрөнгө төвлөрүүлэх хариуцлагыг бусдаас илүү хэмжээгээр хүлээж байгаа этгээд нь Төр юм.

Компани нь өөрийн хувьцааг нэмж гарган нийтэд санал болгохтой холбоотой харилцааг Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээд болох андеррайтерийн компанитай гэрээ байгуулсны үндсэн дээр мэргэжлийн үйлчилгээ авч, үнэт цаасны анхдагч зах зээлд худалдаалах ажлыг хариуцан хэрэгжүүлдэг. Энэхүү мэргэжлийн үйлчилгээний хүрээнд андеррайтер нь компанийн үндсэн үйл ажиллагаа, санхүү, хууль эрх зүйн орчны судалгаа шинжилгээг хийн компанийн чадавхийг тодорхойлсны үндсэн дээр үнэт цаасны зах зээлийн нөхцөл байдалд нийцүүлэн хувьцааг зах зээлд нээлттэй худалдах үнийг тодорхойлдог.

Хувьцаа нэмж гаргаснаар компанийн хувьцаа эзэмшигчдийн саналын эрх дээр дурдсаны дагуу буурдаг бөгөөд Компанийн тухай хуулийн 38.1-д заасны дагуу компаниас нэмж гаргаж байгаа энгийн хувьцааг өөрийн энгийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн тодорхой нөхцлөөр тэргүүн ээлжинд худалдан авах замаар хувьцаа эзэмшигчид нь өөрийн эзэмшлийн хувь хэмжээг бууруулалгүйгээр хадгалан үлдэх боломж нээлттэй байгааг хэлэх нь зүйтэй юм. Давуу эрхийг олгох эсэх асуудлыг дараагийн хурлаар Засгийн газраас чиглэл

авсаны үндсэн дээр шийдье гэсэн учир энийг одоо шийдэх шаардлагагүйн байна. УИХ, Засгийн газрын тогтоолууд та бүхэнд тараасан материалын арын хуудсанд байгаа.

Д.Соёл: Хүмүүс дэлгэцээр гаргаж байгаа зүйлийг анхаараад байна энэ талаар тайлбар хийе. Тэр хувьцааны үнэ бол 9/8-ны байдлаар хөрөнгийн бирж дээр байсан үнийг тавьсан юм.

Ц.Самданпунцаг: Хувьцааны үнэ буураад юуч биш болчих вий дээ гэж санаа зовж байна.

Гүйцэтгэх захирал О.Отгонбаатар: Энэ асуудалыг хурлынхаа дэгийн дагуу дараа нь ярилцая.

Хурлын дарга: Компанийн дүрмийн 12.6.3-дугаар заалтыг өөрчлөн найруулах тухай асуудлыг танилцуулья. 1 дүгээр асуудлын талаар бол ерөнхий ойлголт авсан биздээ гэв.

О.Чинхүсэл: Тус компанийн толгой компани болох “Эрдэнэс Монгол” ХХК-ийн дүрэмд нийцүүлэн нэмэлт өөрчлөлт оруулан, 2014 оны 04-р сарын 26-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар батлагдсан “Шивээ Овоо” ХК-ийн дүрмийн доорхи заалтуудын үйлчлэлийг эргэн харж, өөрчлөх зайлшгүй шаардлага тулгарч байна.

Компаний дүрмийн 12 дугаар зүйлийн 12.6.1.3-д зааснаар “Компанийн батлагдсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй үндсэн хөрөнгө худалдан авах, үндсэн хөрөнгийг актлах данснаас хасах асуудлыг охин компанийн саналыг үндэслэн толгой компани хэлэлцэж шийдвэрлэх эрхтэй” гэсний дагуу шинээр худалдан авах болон ашиглалтаас хасах, акталж устгах, худалдах, шилжүүлэх үндсэн хөрөнгөтэй холбогдох асуудлыг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн түүний төлөөлөн удирдах зөвлөл шийдвэрлэж байгаа билээ.

Үндсэн хөрөнгийг ашиглалтаас хасах, актлах, шинээр худалдан авах, худалдах, шилжүүлэх харилцааг зохицуулсан эдгээр заалтуудыг мөрдөн хэрэгжүүлэх явцад бидэнд дараах хүндрэл тулгарч байна.

1. Ашиглалтын хугацаа дуусч ажлын шаардлага хангахгүй болсон үндсэн хөрөнгүүдийг актлах, дуудлага худалдаагаар худалдан борлуулах дүгнэлтийг компанийн ТУЗ-с дүгнэлт гарган “Эрдэнэс Монгол” ХХК-д хүргүүлэх, түүнчлэн толгой компанийн ТУЗ-с шийдвэр гаргахыг хүлээж цаг хугацаа их алдаж байна.
2. “Шивээ Овоо” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаар 2015 оны 09 дүгээр сард өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах, үүссэн хүндрэлтэй нөхцөл байдлыг даван туулах үүднээс нийт 3-н тэрбум орчим төгрөгийн сэлбэг хэрэгслийг яаралтай худалдан авах нь зүйтэй гэж дүгнэлт гарган толгой компанийн ТУЗ-өөр асуудлыг хэлэлцүүлсэн боловч “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Гүйцэтгэх захирал болон Шивээ Овоо ХК-ийн ТУЗ-д тус асуудлыг шийдвэрлэх эрх олгосон болно.
3. Мөн “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 09 сарын 15-ны өдрийн 28 дугаар тогтоолоор “Шивээ Овоо” ХК-ийн дүрмийн үндсэн хөрөнгийг ашиглалтаас хасах, актлах, шинээр худалдан авах, худалдах, шилжүүлэх харилцааг зохицуулсан эдгээр заалтуудыг Төлөөлөн удирдах зөвлөлд эрх олгох арга хэмжээ авахыг Гүйцэтгэх захирал Б.Бямбасайханд үүрэг болгосон байна.

“Шивээ Овоо” ХК нь төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд учраас компанийн тухай хуульд заасны дагуу үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй эд хөрөнгийн асуудлаа толгой компани болох “Эрдэнэс Монгол” ХХК - аас өгсөн удирдамжийн хүрээнд компанийн

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар шийдвэрлэж, “Эрдэнэс Монгол” ХХК –ийн зүгээс шийдвэрлэгдсэн хөрөнгийн хөдөлгөөнд хяналт тавин ажиллах боломжтой гэж үзэж байна. Ингэснээр цаг хугацаа хожих, эд хөрөнгийн харилцааг түргэн шуурхай зохицуулах, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулахад санхүү мөнгөний зохицуулалтыг шуурхай шийдвэрлэх чухал ач холбогдолтой болно гэж компанийн удирдлагын зүгээс үзэж байна.

Компаний тухай хуулийн шинэчилсэн найруулгад Компанийн шинээр худалдан авах болон актлаж данснаас хасах, худалдах шилжүүлэх эд хөрөнгийн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх талаар Толгой компани, Төлөөлөн удирдах Зөвлөлийн бүрэн эрхийн аль нэгэнд хамааруулахаар зааж өгөөгүй бөгөөд энэхүү асуудлыг компанийг үүсгэн байгуулах дүрмээр зохицуулахаар оруулж өгсөн. Энэ нь уг асуудлыг заавал Толгой компанийн ТУЗ-ийн бүрэн эрхэд давхар хамааруулахгүйгээр Компанийн ТУЗ-ийн бүрэн эрхэд хамааруулж өгөх эрх зүйн боломжтойг харуулж байна.

Иймээс “Шивээ Овоо” ХК-ийн дүрмийн 12 дугаар зүйлийн 12.6.1.3-д “Компанийн батлагдсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй үндсэн хөрөнгө худалдан авах, үндсэн хөрөнгийг актлах данснаас хасах асуудлыг охин компанийн саналыг үндэслэн толгой компани хэлэлцэж шийдвэрлэх эрхтэй гэж заасныг, “Компанийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй үндсэн эд хөрөнгө худалдан авах, үндсэн эд хөрөнгийг данснаас хасах актлах асуудлыг толгой компаниас ирүүлсэн удирдамжийг үндэслэн компанийн ТУЗ шийдвэрлэнэ” гэж өөрчлөн ТУЗ-ийн бүрэн эрхэд хамааруулах саналыг дэмжин Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэх нь зүйтэй байна.

Хурлын дарга: Ерөөсөө юм актлая гэхээр л толгой компанийн ТУЗ- руу явдаг болохоор их хугацаа алддаг. Тэгэхээр энэ асуудлыг компанийн ТУЗ өөрөө шийддэг байх нь их оновчтой шийдвэр гэж үзэж байгаа юм.

Гүйцэтгэх захирал О.Отгонбаатар: Хувьцаа эзэмшигчдийн хурлаас эрх авсан ТУЗ-шийдвэр гаргаж чадахгүй байна гэдэг бол амьдрал дээр хэрэгжихгүйн байна гээд буцааж байгаа асуудал юм.

Хурлын дарга: Толгой компанийн ТУЗ-д энэхүү асуудлыг танилцуулаад ингэж шийдвэрлэх нь үр дүнтэй юм байна гэж үзсэн болно. Гуравдугаар асуудалдаа ороё. Компанийн дүрмийн 10.9, 10.10.10 дүгээр заалтыг хүчингүй болгож 11.1.5 дугаар заалтыг өөрчлөн найруулах тухай

О.Чинхүсэл: Засгийн газрын 2013 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 100 дугаар тогтоолын дагуу Хүний хөгжил санд хөрөнгө төвлөрүүлэх, сангийн хөрөнгийн эх үүсвэрийг тогтворжуулах хүрээнд стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Шивээ Овоо” ХК- ийн төрийн эзэмшлийн хувьцааг “Эрдэнэс Монгол” ХХК-д шилжүүлсэнтэй холбогдуулан тус Компанийн дүрмийг толгой компанийн дүрэмд нийцүүлэн дээрх заалтыг нэмж оруулсан боловч тус заалтыг хэрэгжүүлэх явцад дараах хүндрэл тулгарч байна.

1. Энэхүү заалтын дагуу 2014 онд Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулахаар товлож, бэлтгэл ажлыг хангаж хурлыг зохион байгуулах гэсэн боловч Төрийн эрх барих дээд байгууллагаас Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хийх нь зохимжгүй, хууль зөрчсөн байна гэсэн үндэслэлээр бүтэн сарын хугацаанд татгалзан хойшлуулсны эцэст 2015 оны худалдан авалтын ерөнхий төлөвлөгөө, орон тооны төлөвлөгөө батлах зэрэг асуудлууд хойшлогдох нөхцөл байдлууд бий болсон.
2. Жилийн аль нэг улирал сард улс орны нийгэм эдийн засгийн байдал, хэрэглэгчдийн хөрөнгө санхүүгийн байдлаас шалтгаалан борлуулалт буурах мөнгөний урсгал багасах

магадлал гарах нь их бөгөөд иймэрхүү нөхцөл байдал одооноос ажиглагдаж байна. Улс оронд тулгараад байгаа эдийн засгийн хүндрэл энэ жил улам гүнзгийрэх хандлагатай байгаа нь дээрхи нөхцөл байдал удахгүй бидэнд тулгарахыг сануулж байна. Ийм үед цагаа олсон шуурхай шийдвэр чухал. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан бизнес төлөвлөгөөг тодотгох нь шат дамжлага, зохион байгуулалтын хувьд цаг хугацаа ихээхэн шаарддаг учраас шийдвэрийн цагаа олсон үр дүн, өгөөжийг алдагдуулахад хүргэх муу талтай.

Сүүлийн жилүүдэд ажилласан Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг судлахад төрийн болон бусад хувьцаа эзэмшигчдийн харьцаа өөрчлөгдөөгүй хадгалагдсан үр дүн харагдсан. Иймээс Хувьцаа эзэмшигчийн төлөөлөл нь компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд ажиллаж тэднийг хууль ёсоор төлөөлж байгаа учраас заавал Хувьцаа эзэмшигчдийн хурлын эрх хэмжээнд бизнес төлөвлөгөө батлах болон тодотгол хийх асуудлыг хамааруулах нь төдийлэн оновчтой бус байна.

2011 оны 10 дугаар сарын 6-ны өдөр батлагдсан Компанийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад бизнес төлөвлөгөө батлах асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрх болон Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийн алин нэгэнд хамааруулахаар зааж өгөөгүй бөгөөд энэхүү асуудлыг компанийн үүсгэн байгуулах үндсэн бичиг баримт болох дүрмээр зохицуулахаар оруулж өгсөн. Энэ нь уг асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхэд хамааруулж өгөх бүрэн боломжтойг харуулж байна. Манай компанитай өмчийн хэлбэр адил бусад компаниудын төсөв, бизнес төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах асуудал нь Төлөөлөн удирдах зөвлөлийнхөө бүрэн эрхэд хамаардаг бөгөөд энэ нь жишиг болон тогтсон байна.

Иймээс "Шивээ Овоо" ХК-ийн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.9-д "Тухайн санхүүгийн жилийн 12 дугаар сард Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан, хурлыг тухайн санхүүгийн жилд багтаан хуралдуулж, Компанийн ирэх санхүүгийн жилийн төсөв, бизнес төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батална" гэсэн заалт болон дүрмийн 10.10.10-д Компанийн бизнес төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, төсвийг батлах гэсэн заалтуудыг хүчингүй болгон, 11 дүгээр зүйлийн 11.1.5 дахь "Гүйцэтгэх удирдлагаас боловсруулсан Компанийн бизнес төлөвлөгөө, төсвийн төслийг хэлэлцэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлуулах" гэсэн заалтыг "Гүйцэтгэх удирдлагаас боловсруулсан Компанийн ирэх санхүүгийн жилийн төсөв, бизнес төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах" гэж өөрчлөх нь зүйтэй байна.

Хурлын дарга: "Шивээ Овоо" ХК-ийн зарласан хувьцаанаас 10,261,665 ширхэг хувьцааг хөрөнгийн зах зээлд нэмэлтээр гаргаж олон нийтэд арилжаалах тухай асуудлыг танилцуулая.

Д.Соёл: Засгийн газрын тогтоолын дагуу нэмэлт хувьцаа гаргаад 51 хувь хүртэл бууралахаар нийт 10,261,665 ширхэг хувьцааг гаргаж борлуулах шаардлагатай байгаа юм. Энэ орсон хөрөнгөөр уурхайн техник, технологийг шинэчилье гэж байгаа юм.

Хурлын дарга: 4 дугаар асуудлыг болцон гэж ойлгохуу. 5 дугаар буюу нэмэлт хувьцаа гаргахтай холбоотой асуудлыг Засгийн газраас чиглэл авсаны дараагаар дараагийн хурлаар шийдье гэж тогтсон. Тэгэхээр Олон нийтэд санал болгон арилжаалах хувьцааны санал болгох нэгжийн үнийг тогтоох эрхийг Төлөөлөн удирдах зөвлөлд олгох тухай асуудлаа танилцуулая. Шивээ Овоо ХК-ийн андрейтэрийн байгууллагаа сонгох үнэлгээний хороогоо байгуулагдсан байгаа. Шалгарсан компани нь үнэлгээг нь бүх талаас тогтооно. Тэр үед нь Хувьцаа эзэмшигчдийн хурлаар оруулж цаг алдалгүйгээр үнийг нь тогтоох эрхийг Төлөөлөн удирдах зөвлөлд нь одоо олгоё гэж байгаа юм.

О.Чинхүсэл: Засгийн газрын 2015 оны 330 дугаар тогтоолд бэлтгэл ажлыг 2015 оны 4-р улиралд багтаан хийж 16 онд хувьцааг борлуулах ажлыг хий гэсэн байгаа учраас яаравчлах бас нэг шалтгаан болсон гэж үзэж байна.

Хурлын дарга: За бүх асуудлаа танлцуулаад дууссан тул дэгийн дагуу асуулт хариултыг эхлүүлье.

Д.Энхтуяа: Асуулт байна. Төрийн 90 хувийн өмчтэй компани хувьцаагаа бууруулж байгаа асуудлыг ерөнхийд нь ойлголоо. Сүүлийн 2 асуудлыг тэгэхээр бид нар санал авах хуудсан дээр бөглөхгүй гэж ойлгож болох уу. Ер нь давуу эрх олгож болохгүй юу.

Хурлын дарга: Ер нь бол төр өөрийн хувьцаагаа ингэж доош нь буулгаж байх үед давуу эрх олгохгүй баия гэж анх үзэж Шивээ овоогийн ТУЗ үзсэн. Гэвч толгой компанийн ТУЗ засгийн газар болон холбогдох байгууллагаас санал авсаны үндсэн дээр энэхүү асуудлыг шийдвэрлэе гэж үзсэн байна. Тэгэхээр тэр асуудалтай холбогдох хэсгийг бөглөхгүй орхиод санал хураалт авахгүй байя. Хуулиар бол олгох, эсвэл олгохгүй байхын алинаар ч шийдвэрлэх боломжтой байна.

Ц.Самданпунцаг: Хувьцааг маань бууруулж битгий үзээрэй дээ.

Хурлын дарга: Төрөөс мөнгө өгөх боломжгүй. Бидний зүгээс өөрсдөө л ажил хийх шаардлагатай. Тэгэхээр андрейтерийн компани үнэлгээг тогтоохоор нь та бүхэнд худалдан авах давуу эрх олгох талаас нь л шийдвэрлүүлье гэж үзэж байна. Энэ компанийг ер нь ашигтай ажиллуулах чиг шугаманд нь оруулах гээд л үзээд байна.

Ж.Баатар: Бодит байдлыг хэлэхэд хувьцааны үнэ маань ихээхэн доошилцон байна. Хамгийн сүүлд айр транс, меркис, хөх ган зэрэг компаниуд хувьцаа гаргасан. Энийг тогтоохдоо андрейторын компаниуд тогтоохдоо их буруу тогтоодог гэж бодож байна. Тэгэхээр энэ дээр маш сайн бодож байгаад бүхэлд нь юмуу хэсэгчлэн гаргахыг зөв гаргаарай. Хувьцааны арилжаа ерөөсөө байхгүй байна.

Д.Соёл: Энэ бол стратегийн ач холбогдол бүхий орд газар. Тэгэхээр бид энэ дээр сайн мэдээлэл хүмүүст хүргэж чадвал авахгүй байх гэсэн асуудал гарахгүй байх гэж бодож байна.

“Шивээ Овоо” ХК-ийн зүгээс Гүйцэтгэх захирал О.Отгонбаатар: Өмнө нь гадаад зах зээл дээр гаргая бария гэсэн юм байхгүй байсан. Сая Засгийн газрын тогтоолоор шийдье.

Хурлын дарга: Өмнө нь 20 жилийн турш ямар ч хувьцаанд өөрчлөлт ороогүй бөгөөд менежмент хийх асуудал л байна. Шарын голыг хар л даа.

“Шивээ Овоо” ХК-ийн зүгээс Гүйцэтгэх захирал О.Отгонбаатар: Хувьцааны үнэ буурна гэж санаа зовоод байх нь ерөөсгөл байна. Мэргэжлийн байгууллага гаргаж ирэхээр нь л шийдье. Үнэд угаасаа бүхийл хүчин зүйл нөлөөлнө. Андрейторын байгууллага гаргаж ирсэн үнээрээ борлуулж чадахгүй бол өөрөө хариуцлага хүлээх бас зохицуулалт бас байгаа.

Д.Энхтуяа: Баатрын хэлж байгаатай санал нийлж байна. Бид нарын санал маш их хэрэгтэй. Зах зээлийн үнийг өндөр хөөргөдөх нь буруу. Тэгэхээр үнээ бага тогтоох асуудлыг та бүхэн өөрсдөө ярих нь зүйтэй. 2 дугаарт менежментийг маш сайн хийгээчээ. Ремиконы хувьцааг би алдагдалтай байсан ч авсан. Тэгэхээр энэ асуудлыг Засгийн газрын түвшинд нь ч болсон хэлээд авч явах нь зүйтэй байна. Төлөөлөн удирдах зөвлөлөө сайн хүмүүсээс бүрдүүлээчээ. Бодлогоо зөв боловсруулах асуудлыг Засгийн газрын түвшинд авч яриачээ гэж үзэж байна.

“Шивээ Овоо” ХК-ийн зүгээс Гүйцэтгэх захирал О.Отгонбаатар: 51 хувь болгосоноор жинэхэнэ мэргэшсэн хүмүүс ТУЗ-д орно. Тэгсэнээр засаглал сайжирна гэж үзэж байна.

Б.Пүрэвбаатар: Их хэмжээний хэлцэлтэй холбогдох актлах, худалдах асуудлыг яаж шийдвэрлэх вэ.

Д.Болд: Их хэмжээний хэлцэлийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэнэ. Компанийн тухай хуулиа баримтална. хуулиас давсан дүрэм гэж байж болохгүй.

“Шивээ Овоо” ХК-ийн зүгээс Гүйцэтгэх захирал О.Отгонбаатар: нийт дүрмийн сангийн 11 хувьтай тэнцэх хэмжээний хэлцлийг их хэмжээний хэлцэл гэж үзэж байгаа. Компанийн үндсэн хөрөнгө 93 тэрбум байгаа тэгэхээр энэ дотроо шийдээд явах бүрэн боломжтой гэж үзэж байна. Ямар нэгэн хуультай зөрчилдөхгүй гэж бодож байна.

Хурлын дарга: За өөр санал, асуулт байхгүй бол саналын хуудсаа бөглөөд тооллогын комисст өгөөрэй. Тэгээд тооллогын комиссын дүнтэй танилцуулая.

Тооллогын комиссын дарга С.Одбаяр:

“Шивээ Овоо” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд ирвэл зохих 13,419,101 ширхэг саналын эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс 13,215,891 ширхэг саналын эрх бүхий хувьцаа эзэмшигчид оролцож хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлсэн асуудалд доорх байдлаар саналаа өгсөн байна. Хүчингүй саналын хуудас 0 байна.

1. Компанийн дүрмийн 4.1 дүгээр зүйлд “Компанийн зарласан хувьцаа нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 13,419,101 ш энгийн хувьцаа байна. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь компанийн гаргасан хувьцааг анхдагч зах зээл дээр худалдах үед хувьцаа эзэмшигчдийн худалдан авсан хувьцааны үнэтэй тэнцүү байна” гэснийг “Компани нь нийт 23,680,766 ширхэг зарласан энгийн хувьцаатай байна. Компанийн гаргасан энгийн хувьцаа нь 13,419,101 ширхэг байх бөгөөд энгийн хувьцааны нэг бүрийн нэрлэсэн үнэ 100 төгрөг байна. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь компанийн гаргасан нийт энгийн хувьцааны нэрлэсэн үнийн дүнтэй тэнцүү байна.” гэж өөрчилөх талаар:

зөвшөөрсөн	<u>12,080,375</u>	санал буюу	91,41 хувь
татгалзсан	<u>1,135,516</u>	санал буюу	8.59 хувь
түдгэлзсэн	<u>0</u>	санал буюу	0 хувь

2. Компанийн нэмж зарласан нийт 10,261,665 /арван сая хоёр зуун жаран нэгэн мянга зургаан зуун жаран тав/ ш хувьцааг дотоодын хөрөнгийн биржид олон нийтэд нээлттэй гаргаж арилжаалах эрхийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд олгох талаар:

зөвшөөрсөн	<u>12,080,375</u>	санал буюу	91,41 хувь
татгалзсан	<u>1,135,516</u>	санал буюу	8.59 хувь
түдгэлзсэн	<u>0</u>	санал буюу	0 хувь

3. Компанийн нэмж зарласан нийт 10,261,665 /арван сая хоёр зуун жаран нэгэн мянга зургаан зуун жаран тав/ ш хувьцааг дотоодын хөрөнгийн биржид гаргаж арилжаалах доод үнийг холбогдох хууль, дүрмийн дагуу хараат бус үнэлгээний байгууллагын дүгнэлтийн үндсэн дээр тогтоох эрхийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд олгох талаар:

зөвшөөрсөн	<u>12,080,375</u>	санал буюу	91,41 хувь
татгалзсан	<u>1,135,516</u>	санал буюу	8.59 хувь
түдгэлзсэн	<u>0</u>	санал буюу	0 хувь

4. Компанийн нэмж зарласан нийт 10,261,665 /арван сая хоёр зуун жаран нэгэн мянга зургаан зуун жаран тав/ ш хувьцааг дотоодын хөрөнгийн биржид гаргаж арилжаалахтай холбогдуулан төрөөс бусад энгийн хувьцаа эзэмшигч нь өөрийн эзэмшиж

буй хувьцааны тоотой хувь тэнцүүлэн тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг хувьцаа эзэмшигчдэд эдлүүлж, хувьцааны үнийг компанийн тухай хуулийн 38.4-т заасны дагуу тухайн хувьцааг гаргах үеийн зах зээлд санал болгох үнийн 90 хувьтай тэнцэх үнээр санал болгох талаар

- Хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар тус асуудлыг дараагийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр хойшлуулсанн тул саналын хуудасны энэхүү асуудалтай холбогдох хэсэгт тэмдэглэгээ хийгээгүй буюу санал хураагаагүй болно.

5. “Шивээ Овоо” ХК-ийн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.9-д “Тухайн санхүүгийн жилийн 12 дугаар сард Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан, хурлыг тухайн санхүүгийн жилд багтаан хуралдуулж, Компанийн ирэх санхүүгийн жилийн төсөв, бизнес төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батална” гэсэн заалт болон дүрмийн 10.10.10-д Компанийн бизнес төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, төсвийг батлах гэсэн заалтуудыг хүчингүй болгон, 11 дүгээр зүйлийн 11.1.5 дах “Гүйцэтгэх удирдлагаас боловсруулсан Компанийн бизнес төлөвлөгөө, төсвийн төслийг хэлэлцэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлуулах” гэсэн заалтыг “Гүйцэтгэх удирдлагаас боловсруулсан Компанийн ирэх санхүүгийн жилийн төсөв, бизнес төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах” гэж өөрчилөх талаар:

зөвшөөрсөн	<u>12,080,375</u>	санал буюу	91,41 хувь
татгалзсан	<u>1,135,516</u>	санал буюу	8.59 хувь
түдгэлзсэн	<u>0</u>	санал буюу	0 хувь

6. “Шивээ Овоо” ХК-ийн дүрмийн 12 дугаар зүйлийн 12.6.1.3-д “Компанийн батлагдсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй үндсэн хөрөнгө худалдан авах, үндсэн хөрөнгийг актлах данснаас хасах асуудлыг охин компанийн саналыг үндэслэн толгой компани хэлэлцэж шийдвэрлэх эрхтэй гэж заасныг “Компанийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй үндсэн эд хөрөнгө худалдан авах, үндсэн эд хөрөнгийг данснаас хасах актлах асуудлыг толгой компанийн Гүйцэтгэх захиралаас ирүүлсэн удирдамжийг үндэслэн компанийн Төлөөлөн удирдах зөвлөл шийдвэрлэнэ” гэж өөрчилөх талаар:


зөвшөөрсөн	<u>12,080,375</u>	санал буюу	91,41 хувь
татгалзсан	<u>1,135,516</u>	санал буюу	8.59 хувь
түдгэлзсэн	<u>0</u>	санал буюу	0 хувь

Хурлын дарга: Хурлаас гарах тогтоолын төслийг танилцуулая.

О.Чинхүсэл хурлын тогтоолын төслийг танилцуулсанаар хурал өндөрлөв.

ХУРЛЫН ДАРГА

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН



БЯМБЫН АРИУНБОЛД

ОЧБАТЫН ЧИНХҮСЭЛ